



АУДИТЫН КОД: САГ-2017/15/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл

Утас: 261740 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Ш.Гүрпүрэв

Утас: 261885 Цахим хаяг: gurpurevsh@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	5
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.5	Дотоод хяналт.....	7
2.6	Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар.....	9
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	11
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	11
2.9.1	Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	11
2.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	11
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	12
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	13
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	13
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3	Менежментийн захидал.....	15
3.1	Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	16
3.2	Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар.....	17
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	18
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	18
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	19
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	21
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 751

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөл Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржид танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 5-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн

захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Батсайхан, аудитор Ш.Гүрпүрэв нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 10-нд Үндэсний аудитын газарт Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанаас 5 хоног хоцроож ирүүлсэн байна. Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Наранбилэгийн гарын үсэгтэй 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 04/355 дугаар албан бичгийг Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн хамт шуудангаар илгээсэнтэй холбоотой хугацаа хоцроосон гэсэн тайлбартай байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шүүхийн захиргааны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд :

Шүүхийн ерөнхий зөвлөл 2016 онд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, бэхжүүлэх зорилгын хүрээнд 2013 оноос хэрэгжиж эхэлсэн шүүхийн шинэтгэлийн үр дүнг гүнзгийрүүлэх, түүний ололтыг бататгах, шинэтгэлийн үр дүнг иргэд, олон нийтэд таниулах, шүүхэд олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн шүүхийн үйл ажиллагаа, түүний үр дүн, цаашдын зорилтын талаар 2016 оны Монгол Улсын Шүүхийн тайлангаас мэдээлэл авсан бөгөөд тавьсан зорилт, хөтөлбөрийн хэрэгжилт хангалттай гэж үзжээ. Тухайлбал:

- Шүүхийн шинэтгэлийн үр дүнг олон улсын түвшинд үнэлүүлсэн байна. Олон улсын мэргэшсэн шинжээчдийн хийсэн уг судалгаагаар манай улсын шүүхийн шинэтгэлийг “нийгэм, эдийн засгийн хувьд ижил төстэй гарааны нөхцөлтэй байсан бусад орнуудтай харьцуулахад ихээхэн дээгүүр байна” гэж дүгнэсэн байна.
- Шинэтгэлийн хүрээнд мэдээлийн технологийн зарим дэвшлийг нэвтрүүлснээр шүүх хуралдааны үйл ажиллагаанд дэвшил гарсны гадна хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх улсын хэмжээний мэдээллийн санг цахим програм хангамжийн тусламжтайгаар анх удаа бий болгожээ.
- Шүүхийн сургалтын Баяндөхөм цогцолборыг ашиглалтад оруулснаар шүүх эрх мэдлийн байгууллага сургалт явуулах бааз суурьтай болсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2015 оны 106 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Шүүхийн ерөнхий зөвлөлийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 12 горим, сорил гүйцэтгэн СТАУС програмд оруулав. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам зааврын зарим зүйл, заалттай нийцэхгүй болсон тул уг баримт бичигт дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг

алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны 5 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн Дотоод аудитын албыг байгуулжээ.

Тус алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр шүүхийн захиргаа болон шүүхүүдийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд хяналт тавих
- Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг бэхжүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах
- Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих
- Албаны өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн арга зүйгээр хангах.

Дотоод аудитын алба нь 2016 онд “Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, дүгнэлт, зөвлөмж гаргах дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, төсвийн удирдлага буюу шилэн дансны үйл ажиллагааг шүүхийн системд нэвтрүүлж санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх” зорилт тавьж ажилласан байна.

Дээрх зорилтын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу ажлын алба болон 23 шүүхийн тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд 20 удаагийн шалгалт хийж, 65 хугацаатай зөвлөмж хүргүүлсэн байна. Мөн “Шилэн дансны тухай хууль”-ийн хүрээнд санхүүгийн мэдээлэл оруулах хугацаа бүхий график бэлтгэн вэб сайтад байршуулж, 40 шүүхийн тамгын газарт давхардсан тоогоор 150 зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллажээ.

Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	20	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	20	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	23	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	65
		Дүн /сая.төг/	59,6
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	65

		Дүн /сая.төг/	59,6
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	-
		Дүн /сая.төг/	-

Дээрх шалгалтын явцад нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичгийг боловсруулан баталж үйл ажиллагаандаа мөрдлөгө болгоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өр, авлага, шилэн дансны мэдээлэл дутуу оруулсан, нэг удаагийн тэтгэмжийг олгоходоо холбогдох баримт, материалыг үндэслэдэггүй зэрэг зөрчил дутагдал нийтлэг илэрсэн бөгөөд тухай бүр хугацаатай зөвлөмж өгч ажиллажээ.

Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Говь-Алтай, Увс аймаг, Хэнтий аймгийн Бор-өндөр сум, Ховд аймгийн Булган сум, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь шүүхийн тамгын газрууд “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэх журам”-ын шаардлагыг хангаж, Үндэсний аудитын газраас 2016 оны санхүүгийн тайланд нь санхүүгийн тайлангийн аудит хийлгүй итгэл үзүүлэх шийдвэр гаргасан нь тооны хувьд өнгөрсөн оноос 4 дахин өссөн байна.

Энэ нь дотоод аудитын ажлын үр дүн бөгөөд системийн хэмжээгээр эрсдэл бага, дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

2.6 Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн “тайлант хугацаанд хуулийн хугацаанд шийдвэрлэх хэргийн хувь” гэсэн 1 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг 93.0 хувь байхаар баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 48,267.9 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая.төг/

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	ХУВЬ
		БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,267.9	47,859.8	408.2	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,267.9	47,859.8	408.2	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,764.2	46,357.4	406.8	99.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,503.7	1,502.3	1.4	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,267.9	47,859.8	408.1	99.2

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 99.2 хувьтай байгаа нь Сангийн яам улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлын улмаас төлөвлөсөн зарим зардлын эрхийг хязгаарлах бодлоготой холбоотой 408.2 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд урсгал

зардал, бараа, ажил үйлчилгээний зардал, урсгал шилжүүлэг нийт дүнгээрээ 0.1-0.8 хувиар хэмнэгдсэн байна.

Харин бараа, ажил үйлчилгээний зардлын хэлбэлзлийг зардлын зүйл тус бүрээр авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил 262.3 сая төгрөг буюу 0.8 хувь, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл 40.9 сая төгрөг буюу 0.07 хувь хэмнэсэн нь шүүгчийн орон тооны сонгон шалгаруулалт төлөвлөсөн хугацаанаас хойшилж тайлант хугацаанд батлагдсан орон тоогоор бүрэн ажиллаагүйтэй холбоотой байна.

Гэрэл цахилгааны зардал 3.8 хувь буюу 13.2 сая, түлш халаалт 0.48 хувь буюу 3.7 сая, бичиг хэргийн зардал 4.9 хувь буюу 34.4 сая төгрөгөөр батлагдсан төсөв хэтэрсэн нь тайлант хугацаанд цахилгааны үнэ тариф нэмэгдсэн, нийт анхан шатны журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг өмнөх оноос 13.5 хувь, давж заалдах шатны журмаар шийдвэрлэсэн иргэний хэрэг өмнөх оноос 30.7 хувиар тус тус өссөнтэй холбоотой байна.

Дээрх зардлын хэтрэлт нь хооронд нь шилжүүлж болох бүлгийн дүнгээрээ хэмнэлттэй гарсан байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн гүйцэтгэлд анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэл алга байгаа нь Шүүхийн ерөнхий зөвлөл үйл ажиллагаагаа хэвийн явуулсныг харуулж байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан хөтөлбөрийн хэрэгжилт хангалттай байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албатай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 7 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа 41 нэгж, байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын санал дүгнэлт гаргахаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар 8 байгууллагад итгэл үзүүлж, 32 байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийж санал дүгнэлт гаргасан байна.

Төсвийн шууд захирагч нарын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийх явцад нийт 261.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний дотор 3 шүүхийн Тамгын газарт 7.7 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 8 шүүхийн Тамгын газарт 85.0 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлжээ.

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, залруулгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэгж тус бүрээр гаргаж, ажлын баримт материалд хавсаргав.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад өгсөн зөвлөмж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх

2.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилоор материаллаг бус дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

2.9.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад хийсэн залруулгын талаар

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн уялдааг шалгах аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад татварын бус орлогод хамаарах 5.1 сая төгрөгийн орлогыг татварын орлогын “Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт” дансанд тусгаж, буруу тайлагнасан байна.

Энэ нь холбогдох ажилтнууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс гадна Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 5.1 сая төгрөгийн орлогыг татварын бус орлогод оруулж, аудитын явцад залруулга хийлээ.

2.9.2.2 Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны санхүү, хөрөнгө оруулалтын газрын хариуцаж ажил гүйлгээ хийдэг харилцах дансны орлого, зарлагын гүйлгээнд түүвэр шалгалт хийхэд 2016 онд 29.0 сая төгрөгийн шатахуун худалдан авсан бөгөөд хөдөө, орон нутагт томилолтоор ажилласан ажилтнуудад олгосон 24.1 сая төгрөгийн шатахууныг зардалд тусгахдаа шатахууны тооцоо бодож баримтжуулаагүй, замын хуудас болон шатахууны зардалд олгосон мөнгөний зарцуулалттай холбоотой анхан шатны баримтыг бүрдүүлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сулруулсантай холбоотой байна. Хуулийн хүчин төгөлдөр анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой бодлого, журам, зааврыг мөрдөж, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны санхүү, хөрөнгө оруулалтын газрын хариуцаж ажил гүйлгээ хийдэг харилцах дансны орлого, зарлагын гүйлгээнд түүвэр шалгалт хийхэд Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газрын байрны шүүх хуралдааны танхимын засварын 139.2 сая төгрөгийн ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, Монгол улсын Засгын газрын 2013 оны 309 дүгээр тогтоолыг үндэслэн нууцын зэрэглэлтэй гэж үзэн тендер зарлалгүй гүйцэтгэгчийг сонгон хэрэгжүүлсэн байна.

Нууцын зэрэглэлтэй барилга байгууламж барих, засварлах ажлыг ямар байгууллага, ямар шалгуураар хийх ёстой талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь эдгээр ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сулруулж байгаа тул цаашид анхааралдаа авах нь зүйтэй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, аудитын зарим чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, түүний хэрэгжилтийн байдалд системийн хэмжээнд нэгтгэсэн дүгнэлт гаргах
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагааны талаар нэгдсэн дүгнэлт гаргах
- Цалин хөлс, урамшууллын төлөвлөлтийн үндэслэл, гүйцэтгэлд аудит хийх

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 291.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, 7.5 сая төгрөгийн алдааг залруулж, 283.6 сая төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчлийг нэгтгэж баталгаажуулав.

Дээрх зөрчлийн талаарх мэдээллийг дараах байдлаар ангилан үзүүлэв.

№	Үзүүлэлт	/мян.төг/					
		Аудитын явцад илрүүлсэн нийт алдаа, зөрчил		Аудитын явцад хийсэн залруулга		Залруулаагүй алдаа, зөрчлийн дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил	59	261,902.5	3	2,431.3	56	259,471.2
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил	2	29,175.60	1	5,075.6	1	24,100.0
	Дүн	61	291,078.1	4	7,506.9	57	283,571.2

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, дотоод аудитын алба хяналт тавьж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар тооны хувьд 85,7 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанаас Үндэсний аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 04/1244 дүгээр албан бичгээр ирүүлсэн болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 49,979.1 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 999.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн аудитын байгууллага Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 41 байгууллага, нэгжээс 1 байгууллагыг түүвэрт хамруулан, 8 байгууллагад итгэл үзүүлж, 32 байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийж, санал дүгнэлт гаргасан бөгөөд 31 байгууллагад зөрчилгүй, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газар болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан, цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

**3.1 Төсвийн шууд захирагчийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХЭД
ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа 32 төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 261.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3 шүүхийн Тамгын газарт 7.7 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 8 шүүхийн Тамгын газарт 85.0 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлжээ. Нийт 44 шүүхийн Тамгын газарт 166.8 сая төгрөгийн зөвлөмж өгч, 3 Тамгын газрын 2.4 сая төгрөгийн алдаанд залрууллага хийсэн байна.

Эрсдэлүүд

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг нэгтгэсэн байдлаар гаргаж, үнэлэлт өгөх

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны санхүү, хөрөнгө оруулалтын газрын хариуцаж ажил гүйлгээ хийдэг харилцах дансны орлого, зарлагын гүйлгээнд түүвэр шалгалт хийхэд 2016 онд 29.0 сая төгрөгийн шатахуун худалдан авсан бөгөөд хөдөө, орон нутагт томилолтоор ажилласан ажилтнуудад олгосон 24.1 сая төгрөгийн шатахууныг зардалд тусгахдаа шатахууны тооцоо бодож баримтжуулаагүй, замын хуудас болон шатахууны зардалд олгосон мөнгөний зарцуулалттай холбоотой анхан шатны баримтыг бүрдүүлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сулруулсантай холбоотой байна. Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудыг хэрэгжүүлдэг байх

ҮАГ-ын зөвлөмж

Шатахууны зардлын тооцоог нөхөн хийж, холбогдох анхан шатны баримт материалыг бүрдүүлэх

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой бодлого, журам, зааврын хэрэгжилт, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мянган төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,039,712.8	1,006,624.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	299,007.3	81.3
312	БАНКИНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ	299,007.3	81.3
33	АВЛАГА	66,071.1	39,035.0
34	УРЬДЧИЛГАА	1,948.8	5,590.8
35	БАРАА МАТЕРИАЛ	672,685.4	961,917.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	38,920,309.6	40,078,225.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	38,920,309.6	40,078,225.5
392	БИЕТ ХӨРӨНГӨ	38,106,055.0	39,310,712.7
393	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	814,254.5	767,512.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	39,960,022.4	41,084,850.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	365,034.5	80,658.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	365,034.5	80,658.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	39,594,987.8	41,004,191.4
51	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	39,594,987.8	41,004,191.4
511	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ /ЗАСГИЙН ГАЗРЫН САН/ ОРОН НУТГИЙН САН	17,284,911.6	17,284,911.6
512	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	15,223,216.9	16,632,593.3
51300	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨРҮҮ	7,086,859.2	7,086,686.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	39,960,022.4	41,084,850.3

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мянган төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	50,625,334.2	51,365,641.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,389.3	2,945,710.1
120	Нийтлэг татварын бус орлого	139,109.8	2,766,878.3
122	Тусламжийн орлого	43,279.5	178,831.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,442,944.9	48,419,931.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	50,435,059.4	48,226,016.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,885.4	193,915.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	50,124,214.1	49,966,242.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,124,214.1	49,966,242.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,202,691.6	48,053,802.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,154,318.0	34,447,110.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,754,106.1	3,770,428.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,301,866.8	1,345,401.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,129,424.0	2,224,174.6
2105	Нормативт зардал	22,943.4	11,829.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,207,662.1	787,968.7
2107	Томилолт, зочны зардал	298,789.6	310,291.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,193,577.5	1,106,635.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,140,003.8	4,049,961.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,921,522.4	1,912,440.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	111,290.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,158,226.0	1,502,314.6
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,652,006.3	410,125.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	501,120.1	1,399,399.3
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,171.7	12,925.6
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,171.78)	(12,925.63)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	493,948.3	1,386,473.7

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мянган төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧ
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,167,990.8		39,167,990.8
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-6,784,276.7		-6,784,276.7
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	32,383,714.1		32,383,714.1
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-2,429.3		-2,429.3
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	6,719,754.7		6,719,754.7
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн	493,948.3		493,948.3
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,594,987.8		39,594,987.8
D01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	39,594,987.8		39,594,987.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	22,902.5		22,902.5
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,617,890.3		39,617,890.3
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-172.6		-172.6
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00		0.00
D08	Тайлант үеийн үр дүн	1,386,473.7		1,386,473.7
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,004,191.4		41,004,191.4

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мянган төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	51,154,791.6	49,341,047.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	238,339.3	583,349.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,916,452.2	48,757,698.2
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	50,435,059.4	48,226,016.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	168,968.4	159,480.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	312,424.3	372,201.9
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,448,610.9	49,350,667.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,448,610.9	49,350,667.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,196,808.4	47,064,205.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,186,680.5	34,415,006.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,741,121.1	3,777,505.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,296,770.0	1,362,829.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,994,876.7	2,216,990.8
2105	Нормативт зардал	18,979.7	25,937.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,998,042.4	2,768,518.2
2107	Томилолт, зочны зардал	299,479.0	330,143.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,321,778.8	1,421,230.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	339,079.9	746,042.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,251,802.5	2,286,462.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	111,290.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,486,817.90	1,873,674.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,653,694.5	412,787.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	706,180.7	(9,620.10)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	674,423.4	289,305.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	674,423.4	289,305.9
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(674,423.45)	(289,305.94)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,757.2	(298,926.04)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	267,250.1	299,007.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	299,007.3	81.3

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Мянган төгрөгөөр/

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	ХУВЬ
		БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,267,942.5	47,859,762.4	408,180.0	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,267,942.5	47,859,762.4	408,180.0	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,764,247.7	46,357,447.8	406,799.8	99.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,677,296.5	34,415,006.9	262,289.5	99.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,818,393.3	3,777,505.4	40,887.8	98.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,376,187.8	1,362,829.5	13,358.2	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,176,759.8	2,174,339.8	2,419.9	99.9
2105	Нормативт зардал	26,949.2	25,537.8	1,411.4	94.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,017,278.8	2,990,546.9	26,731.8	99.1
2107	Томилолт, зочны зардал	321,067.7	312,194.6	8,873.0	97.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,157,160.5	1,107,961.4	49,199.0	95.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	193,154.1	191,525.1	1,629.0	99.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,503,694.8	1,502,314.6	1,380.2	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,503,694.8	1,502,314.6	1,380.2	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,267,942.50	47,859,843.7	408,098.7	99.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,257,942.5	47,825,893.3	432,049.1	99.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000.0	33,950.4	(23,950.44)	339.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		81,331.0		
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	79.0	79.0		
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2,012.0	1,872.0	140	
	Удирдах ажилтан	156.0	156.0		
	Гүйцэтгэх ажилтан	1,178.0	1,178.0		
	Үйлчлэх ажилтан	678.0	538.0	140	